

ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬД ТӨРИЙН АУДИТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ТУСГАСАН ТАЛААРХ ЛАВЛАГАА

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ

Мэдээлэл, лавлагаанд гадаадын улс орнууд Үндсэн хууль²²⁵-даа Төрийн аудиттай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулсныг судалсан болно.

Хүснэгт 1. Төрийн аудиттай холбоотой асуудлыг тусгасан байдал

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1	Дани	<p>47.1.Төрийн тооцоог санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 6 сарын дотор Фолкетингт танилцуулна.</p> <p>47.2.Фолкетинг аудиторуудыг сонгоно. Аудиторууд нь жилийн Төрийн тооцоог хянан шалгана. Төрийн тооцоонд улсын бүх орлогыг тусгасан байх ба Сангийн тухай болон Төсвийн тухай хуулиудад заагаагүй зардлыг санхүүжүүлэхгүй. Аудиторууд шаардлагатай мэдээллийг шаардах болон шаардлагатай баримт бичгийг авах эрхтэй. Аудиторуудын бүрэлдэхүүний тоог тогтоох, тэдний эрх, үүргийг журмаар тогтооно.</p> <p>47.3.Төрийн тооцоог аудитын тайлангийн хамт Фолкетингээр шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ.</p>
2	ХБНГУ	<p>114 дүгээр зүйл. Тооцоог танилцуулах ба хянан шалгах</p> <p>1.Холбооны Засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор холбооны Сангийн сайд жил бүр Бундестаг болон Бундесратад өмнөх жилийн төсвийн бүх орлого, зарлага, актив, өрийн тайланг танилцуулна.</p> <p>2.Холбооны Аудитын танхим нь бие даасан байгууллага ба данс бүртгэлийг шалгаж, төрийн санхүүг зохих ёсоор үр ашигтай зарцуулсан эсэхийг тодорхойлно. Танхим нь жилийн тайланг Бундестаг, Бундестрат болон холбооны Засгийн газарт хүргүүлнэ. Бусад тохиолдолд холбооны Аудитын танхимын эрх, үүргийг холбооны хууль тогтоомжоор зохицуулна.</p>
3	Бельги	<p>180 дугаар зүйл.</p> <p>Аудитын танхимын гишүүдийг Төлөөлөгчдийн танхимаас хуульд заасан хугацаагаар томилно.</p> <p>Аудитын танхим нь захиргааны нэгдсэн тооцоо болон төрийн сангийн дансны хариуцлагатай нягтлан бодох бүртгэлийг шалгах, баталгаажуулах үүрэгтэй. Танхим нь төсөв хэтрүүлсэн ямар нэгэн шилжүүлэг хийгдсэн эсэхийг хянана. Танхим нь улсын төсвийн зарлага, татварын болон бусад орлогод тавих ерөнхий хяналтыг тавина. Энэ танхим нь төрийн бүх байгууллагын дансанд клеринг хийх ба үүний тулд шаардлагатай бүх мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн баримтыг цуглуулах үүрэгтэй. Нэгдсэн тооцоог Аудитын танхимын хийсэн шинжилгээний хамт Төлөөлөгчдийн танхимд танилцуулна.</p> <p>Аудитын танхимын үйл ажиллагааг хуулиар зохицуулна.</p> <p>Аудитын танхимын олон нийт, орон нутаг, мөн тэднээс хамааралтай нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын төсөв, нягтлан бодох бүртгэлд хяналт тавихыг хуулиар зохицуулна. Хуулиар мөн Танхимын хяналтын чиг үүргийг холбооны хууль, эсхүл энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна. Герман хэлээр яригчдын нийгэмлэгт хамаатайгаас бусад тохиолдолд хуулийг энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу олонхын саналаар батална.</p> <p>Хууль, холбооны хууль, эсхүл энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмын дагуу Аудитын танхимд нэмэлт даалгавар өгч болно. Хэрэв Танхим нь холбооны хууль, энэ хуулийн 134 дүгээр зүйлд заасан журмыг биелүүлэхийг зөвшөөрсөн бол Танхим энэ даалгаврын төлбөрийн хэмжээг тогтооно.</p> <p>Энэ заалтыг хүчин төгөлдөр болохоос өмнө олон нийт, орон нутагт зориулж биелүүлсэн даалгаврын хөлсийг Танхимд төлөхгүй.</p>

²²⁵Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

4	Финланд	<p>90 дүгээр зүйл. Улсын санхүүгийн хяналт ба аудит Парламент нь улсын санхүү, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих ба энэ зорилгоор Парламент Аудитын хороотой байна. Аудитын хороо нь хяналтын аливаа чухал дүгнэлтийг Парламентад тайлагнана. Улсын санхүү, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Парламентын дэргэд бие даасан Үндэсний аудитын газартай байна. Үндэсний аудитын газрын эрх зүйн байдал, эрх, үүргийг хуулиар нарийвчлан тогтооно. Аудитын хороо болон Үндэсний аудитын газар нь өөрсдийн хяналтад байдаг төрийн болон бусад байгууллагаас эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг авах эрхтэй.</p>
5	Франц	<p>47-2 дугаар зүйл. Тооцооны танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад Парламентад туслалцаа үзүүлнэ. Танхим нь Санхүүгийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж Парламент болон Засгийн газарт туслалцаа үзүүлнэ. Танхим нь иргэдийг мэдээллээр хангана. Төрийн захиргааны данс нь хууль ёсны бөгөөд баталгаатай байна. Тэдгээр нь төрийн өмчийн удирдлага, хөрөнгө, санхүүгийн үр дүнгийн талаар үнэн зөв, шударга төсөөллийг хангана.</p>
6	Литва	<p>12 дугаар бүлэг. Төрийн хяналт 133 дугаар зүйл. Төрийн хяналтыг гүйцэтгэх тогтолцоо, эрх, үүргийг хуулиар тогтооно. Төрийн хяналтын удирдлагыг Төрийн хянагч хэрэгжүүлэх ба түүнийг Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн танилцуулснаар Сейм 5 жилийн хугацаатай томилно. Төрийн хянагч нь албан үүргээ хүлээн авахдаа тангараг өргөнө. Тангаргийг хуулиар зохицуулна. 134 дүгээр зүйл. Төрийн хяналт нь төрийн өмчийн удирдлага, ашиглалт, улсын төсвийн гүйцэтгэлийн хууль ёсны байдалд хяналт тавина. Төрийн хянагч нь жилийн төсвийн гүйцэтгэлийн талаарх дүгнэлтээ Сеймд танилцуулна.</p>
7	Эстони	<p>11 дүгээр бүлэг. Төрийн аудитын газар 132 дугаар зүйл. Төрийн аудитын газар нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд бие даасан төрийн байгууллага бөгөөд эдийн засгийн хяналтыг хэрэгжүүлнэ. 133 дугаар зүйл. Төрийн аудитын газар дор дурдсан асуудлыг хянана: 1) төрийн байгууллага, төрийн үйлдвэрийн газар болон бусад төрийн байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа; 2) төрийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт; 3) орон нутгийн засаг захиргааны хяналтад шилжүүлсэн төрийн хөрөнгийг ашиглалт, удирдлага; 4) төр 50-аас дээш хувийн саналын эрх, эсхүл хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн буюу төрөөс баталгаа гаргаж зээл авсан, эсхүл гэрээний үүргийг биелүүлж байгаа хуулийн этгээдийн эдийн засгийн үйл ажиллагаа. 134 дүгээр зүйл. Төрийн аудитын газрыг Ерөнхий аудитор удирдана. Ерөнхий аудиторыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Рийгигогу (Төрийн зөвлөл) томилох ба чөлөөлнө. Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байна. 135 дугаар зүйл. Ерөнхий аудитор нь өмнөх төсвийн жилд төрийн өмчийн ашиглалт, хадгалалтын талаарх тоймыг улсын төсвийн хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэхтэй нэгэн зэрэг Рийгигогу (Төрийн зөвлөл)-д танилцуулна. 136 дугаар зүйл. Ерөнхий аудитор нь Бүгд найрамдах улсын Засгийн газрын хуралдаанд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар үг хэлэх эрхтэйгээр оролцож болно. Ерөнхий аудитор нь Төрийн аудитын газрын удирдах албан тушаалтны хувьд сайдтай адил эрх эдэлнэ. 137 дугаар зүйл. Төрийн аудитын газрын зохион байгуулалтыг хуулиар тогтооно. 138 дугаар зүйл. Ерөнхий аудиторыг гагцхүү Хууль зүйн сайдын саналын дагуу Рийгигогу (Төрийн зөвлөл)-ийн гишүүдийн олонхын саналаар эрүүгийн хариуцлагад татаж болно.</p>

8	Унгар	<p>43 дугаар зүйл. 1.Төрийн аудитын газар нь Үндэсний Ассамблейн харьяа санхүү, эдийн засгийн аудитын асуудал эрхэлсэн байгууллага байна. Төрийн аудитын газар нь хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төвлөрсөн төсвийн хэрэгжилт, төсвийн санхүүжилтийн удирдлага, ашиглалт, үндэсний хөрөнгийн удирдлагад хяналт тавина. Төрийн аудитын газар нь хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль ёс, зорилгод тулгуурласан, үр нөлөөтэй байх шалгуурт нийцүүлнэ. 2.Төрийн аудитын газрын Ерөнхийлөгчийг Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ын саналаар 12 жилийн хугацаатайгаар сонгоно. 3.Төрийн аудитын газрын Ерөнхийлөгч нь жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Үндэсний Ассамблейд тайлагнана. 4.Төрийн аудитын газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны нарийвчилсан журмыг хуулиар тогтооно.</p>
9	Чех	<p>62 дугаар зүйл. Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь: j.Аудитын ерөнхий газрын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилно; 5 дугаар бүлэг. Аудитын ерөнхий газар 97 дугаар зүйл 1.Аудитын ерөнхий газар нь бие даасан байгууллага байна. Тус газар төрийн өмчийн удирдлага, улсын төсвийн гүйцэтгэлд аудит хийнэ. 2.Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч нь Аудитын ерөнхий газрын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг Депутатуудын Ассамблейгаас нэр дэвшүүлсний дагуу томилно. 3.Аудитын ерөнхий газрын эрх зүйн байдал, эрх, үүрэг, зохион байгуулалтын бүтэц, түүнчлэн илүү нарийвчилсан зохицуулалтыг хуулиар тогтооно.</p>
10	Польш	<p>9 дүгээр хэсэг. Төрийн хяналтын байгууллага ба Хяналтын дээд танхимын эрхийг хамгаалах 202 дугаар зүйл. 1.Хяналтын дээд танхим нь төрийн хяналтын дээд байгууллага байна. 2.Хяналтын дээд танхим Сеймд захирагдана. 3.Хяналтын дээд танхим нь үйл ажиллагаагаа хамтын зарчимд нийцүүлж явуулна. 203 дугаар зүйл. 1.Хяналтын дээд танхим нь Засгийн газрын байгууллагууд, Польшийн Үндэсний банк, улсын хуулийн этгээд болон төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн үр ашиг, чиг үүрэгт хяналт тавина. 2.Хяналтын дээд танхим нь нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн хэмнэлт, үр ашигт хяналт тавина. 3.Хяналтын дээд танхим нь төрийн болон нийтийн өмч буюу нөөцийг ашигладаг байгууллагууд, эдийн засгийн субъектүүдийн үйл ажиллагааны хуульт ёс, эдийн засгийн үр ашигт болон төрд ашигтай байх санхүүгийн зорилгын биелэлтэд хяналт тавина. 204 дүгээр зүйл. 1.Хяналтын дээд танхим Сеймд тайлагнана: 1) улсын төсвийн гүйцэтгэл, мөнгөний бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ; 2) өмнөх жилийн улсын төсвийн гүйцэтгэлийн талаарх Сайд нарын Зөвлөлийн тайланг батлах тухай шийдвэрийн дүгнэлт; 3) хуульд заасан хяналт шалгалт, дүгнэлт, саналын талаар мэдээлэл. 2.Хяналтын дээд танхим нь жил бүр үйл ажиллагаагаа Сеймд тайлагнана. 205 дугаар зүйл. 1.Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг Сейм Сенаттай зөвшилцсөний дараа 6 жилийн хугацаагаар томилох ба зөвхөн нэг удаа улируулан томилж болно. 2.Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгч нь дээд боловсролын байгууллагын профессороос бусад албан тушаал болон аливаа мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж болохгүй. 3.Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгч нь улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, өөрийн албан үүрэгт нийцэхгүй олон нийтийн үйл ажиллагаанд хамаарч болохгүй. 206 дугаар зүйл. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг Сеймийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах буюу эрх чөлөөг хасаж болохгүй. Хяналтын дээд танхимын Ерөнхийлөгчийг гэмт хэргийн газарт нотлох баримттай нь саатуулахаас бусад тохиолдолд саатуулах, эсхүл баривчилж болохгүй. Ийм саатуулах ажиллагааны талаар Сеймийн Маршалд нэн даруй мэдэгдэх ба тэрээр саатуулагдсан Ерөнхийлөгчийг нэн даруй чөлөөлөхийг шаардаж болно. 207 дугаар зүйл. Хяналтын дээд танхимын бүтэц, үйл ажиллагааг хуулиар тогтооно.</p>

11	Словак	<p>2 дугаар хэсэг. Бүгд найрамдах Словак Улсын Аудитын ерөнхий газар 60 дугаар зүйл.</p> <p>1.Бүгд найрамдах Словак Улсын Аудитын ерөнхий газар нь дараах асуудалд хяналтыг хэрэгжүүлэх бие даасан байгууллага болно:</p> <p>а.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөл, эсхүл Засгийн газраас баталсан төсвийн нөөц;</p> <p>б.төр, төрийн байгууллага, Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний өмчийн сан, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний өмчийн сангийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагын байгуулсан хуулийн этгээдийн өмч, өмчийн эрхүүд, сангууд, үүргүүд, нэхэмжлэлүүд;</p> <p>с.Хөгжлийн хөтөлбөр хүрээнд, эсхүл бусад төстэй шалтгаанаар гадаадын орноос хуулийн этгээд, эсхүл хувь хүн Бүгд найрамдах Словак Улсад шилжүүлсэн өмч, өмчийн эрхүүд, сангууд, нэхэмжлэлүүд;</p> <p>д.Бүгд найрамдах Словак Улс баталгааг нь гаргасан өмч, өмчийн эрхүүд, сангууд, үүргүүд, нэхэмжлэлүүд;</p> <p>е.нийтийн ашиг сонирхлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн өмч, өмчийн эрхүүд, сангууд, үүргүүд, нэхэмжлэлүүд.</p> <p>2.Аудитын ерөнхий газар нь дараах байгууллагуудад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүрээнд хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:</p> <p>а.Бүгд найрамдах Словак Улсын Засгийн газар, яамд, Бүгд найрамдах Словак Улсын төрийн захиргааны төв байгууллагууд болон түүний харьяа байгууллагууд;</p> <p>б.төрийн байгууллагууд, мөн төрийн захиргааны төв байгууллагууд, эсхүл тэдгээрийн байгуулсан хуулийн этгээд;</p> <p>с.орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагууд, орон нутгийн байгууллагын болон нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагын байгуулсан хуулийн этгээд, орон нутгийн болон нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>д.тусгай зориулалтын төрийн сангууд, хуулиар байгуулагдсан төрийн байгууллагууд, төрийн байгууллагын өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>е.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний өмчийн сан болон түүний өмчийн оролцоотой хуулийн этгээд;</p> <p>ф.хувь хүн, хуулийн этгээд.</p> <p>61 дүгээр зүйл.</p> <p>1.Аудитын ерөнхий газрыг дарга удирдана. Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргыг Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлөөс сонгох ба эгүүлэн татна.</p> <p>2.Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний Зөвлөлд сонгогдох эрхтэй Бүгд найрамдах Словак Улсын аливаа иргэн Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргаар сонгогдож болно.</p> <p>3.Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргаар 7 жилийн хугацаатайгаар сонгогдох ба дараалан хоёр удаа сонгогдож болно.</p> <p>4.Аудитын ерөнхий газрын дарга, орлогч даргын албан тушаал нь өөрийн өмчийг удирдах, шинжлэх ухаан, боловсрол, утга зохиол, урлагийн үйл ажиллагаанаас бусад төрийн захиргааны ямар ч байгууллагад, бизнесийн үйл ажиллагаанд ажил эрхлэх, түүнтэй адилтгах хөдөлмөрийн харилцаанд орох, бизнесийн, эсхүл эдийн засаг, арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн удирдлага, эсхүл хяналтын байгууллагын гишүүнчлэлийг хавсран хийхгүй.</p> <p>62 дугаар зүйл.</p> <p>Аудитын ерөнхий газар нь хяналт шалгалтын үр дүнгийн тайланг Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлд жилд 1-ээс доошгүй удаа, мөн Бүгд найрамдах Словак Улсын Үндэсний зөвлөлийн хүссэн тохиолдол бүрт гаргана.</p> <p>63 дугаар зүйл.</p> <p>Аудитын ерөнхий газрын эрх зүйн байдал, эрх, үүрэг, дотоод зохион байгуулалтын бүтэц, хяналт хийх үндсэн журмыг хуулиар тогтооно.</p>
----	--------	--

12	Словени	<p>150 дугаар зүйл. Аудит Аудит нь төрийн данс, улсын төсөв, улсын бүх төрлийн зардалд хяналт шалгалт хийх дээд байгууллага байна. Аудитын зохион байгуулалт, эрх, үүргийг хуулиар тогтооно. Аудит нь чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх ба Үндсэн хууль болон бусад хуульд захирагдана. 151 дүгээр зүйл. Аудитын гишүүдийг томилох Аудитын гишүүдийг Үндэсний Ассамблейгаас томилно.</p>
13	БНСУ	<p>4 дүгээр дэд бүлэг. Хянан шалгах зөвлөл 97 дугаар зүйл. Хянан шалгах зөвлөл нь Ерөнхийлөгчийн шууд мэдэлд байгуулагдах ба улсын төсөв, хууль тогтоомжоор байгуулсан төрийн байгууллага, гүйцэтгэх байгууллагын албан тушаалтны төсвийн удирдлагыг хянан шалгана. 98 дугаар зүйл. 1) Хянан шалгах зөвлөл нь даргыг оролцуулан 5-аас доошгүй, 11-ээс дээшгүй гишүүнээс бүрдэнэ. 2) Зөвлөлийн даргыг Үндэсний Ассамблейн зөвшөөрлөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба түүнийг нэг удаа улиран томилж болно. 3) Зөвлөлийн гишүүдийг Зөвлөлийн даргын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба тэдгээрийг нэг удаа улиран томилж болно. 99 дүгээр зүйл. Хянан шалгах зөвлөл нь жил бүр орлого, зарлагын дансны хаалтын дүнд хяналт шалгалт хийж, тайланг дараа жил Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейд тайлагнана. 100 дугаар зүйл. Хянан шалгах зөвлөлийн зохион байгуулалт, эрх, үүрэг, түүний гишүүдийн мэргэшил, хяналт шалгалтад хамрагдах төрийн албан тушаалтны хүрээ, бусад шаардлагатай зохицуулалтыг хуулиар тогтооно.</p>